



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/68

Алтай хот

Улсын хошой болон аварга малчид,
 аварга тариаланчдад хүндэтгэл үзүүлэх
 тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь :

1. "Улсын хошой аварга малчин"-аар шалгарсан Халиун сумын Чацран багийн малчин Банзрагчийн Мулч, "Улсын аварга малчин"-аар шалгарсан Жаргалан сумын Бүрэн багийн малчин Чулуунбаатарын Лхагваа, Тайшир сумын Далан багийн малчин Дэлгэрийн Батболд, Тонхил сумын Алтансоёмбо багийн малчин Бат-Очирын Мянганбаяр, Төгрөг сумын Тунгалаг багийн малчин Тардадын Чулуунбаатар, Цээл сумын Жаргалт багийн малчин Чулуунбатын Гансүх, "Улсын аварга тариаланч"-аар шалгарсан Бигэр сумын иргэн Ивановын Болдбаатар нарт хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Шаардагдах 6,084,500 (зургаан сая наян дөрвөн мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батзоригт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны
01 дугаар сарын 31 ны өдрийн 1168 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжээ	Нэгж үнэ	Нийт
1	Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардал	7 ширхэг	580,000	4,060,000
2	Мөнгөн аяга	7 ширхэг	265,000	1,855,000
3	Хадаг	14 ширхэг	6,750	94,500
4	Чихэр	3 кг	25,000	75,000
Нийт дүн:				6,084,500

__оОо__